



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/177

Номгон

Малын халдварт өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 04/06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл (технологит) хугацаанд орон нутаг, мэргэжлийн байгууллагууд хамтран чанар, үр дүнтэй зохион байгуулсугай.


2. Холбогдох байгууллагатай 188,835,397.00 (Нэг зуун наян найман сая найман зуун гучин таван мянга гурван зуун ерэн долоон) төгрөгийн вакцин, био бэлдмэл худалдан авах гэрээг байгуулан, санхүүжилтийг орон нутгийн төсвөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. Малчид, аж ахуй нэгжийн хөрөнгөөр худалдан авах “Сохор догол, Шөвөг яр, Сахуугаас сэргийлэх вакцин”-ны татан авалт, нийлүүлэлтийн гэрээг байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн хэмжээнд дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн хугацаанд тухайн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

5. Захирамжийн хэрэгжилт, гэрээнүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220435